


BYU



BYU  
IDAHO



BYU  
HAWAII



BYU  
PATHWAY



ENSIGN  
COLLEGE



INSTITUTES  
OF RELIGION



# Сүмийн боловсролын систем

**СБС-ийн эрхэм зорилго:** Өөрсдийн гэр орон, Сүм, орон нутагт удирдагч болох Есүс Христийн шавь нарыг төрүүлэх.

## Израилын цугларалт:

“Өнөөдөр энэ Сүмд болж буй Израилын агуу цугларалтад Их Эзэн боловсролыг ашиглаж байна. Тэрээр эргэн ирэхдээ зориулж дэлхийг бэлтгэж байгаа бөгөөд Сүмийн боловсролын систем бол Түүний энэхүү хүчин чармайлтад зориулагдсан олон эх сурвалжийн нэг билээ. Институт бүр дэлхий даяарх Сүмийг адислахын тулд өөр өөр зүйлийг хийдэг. Институт бүр Сүмийн удирдлагыг дэлхийгээс ялгаатай байлгахыг зорьдог ба сонирхолтой нь бие биеэсээ ялгарах өөрийн зорилго, үүрэг хариуцлагатай байдаг.”

—Ахлагч Кларк Г.Гилбэрт, Сүмийн боловсролын системийн бүрэн эрхт төлөөлөгч

Боломж тус бүрийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл [cesinfo.byu.edu](mailto:cesinfo.byu.edu) руу орж **БҮРТГҮҮЛНЭ ҮҮ.**

Эдгээр сонголтын аль нэгд хандаж **ХҮСЭЛТ ГАРГАХ БОЛ** [apply.ChurchofJesusChrist.org](https://apply.ChurchofJesusChrist.org) вэбсайтад зочил.

Энэхүү тараах материалын дараагийн хуудаснаас институт бүрийн талаарх **ДЭЛГЭРЭНГҮЙ** мэдээллийг авна уу.

## БРИГАМ ЯНГИЙН ИХ СУРГУУЛЬ

Бригам Янгийн Их Сургуулийн (БЯИС) эрхэм зорилго нь хувь хүмүүст төгс төгөлдөр байдал, мөнх амьдралыг эрэлхийлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэдэг. БЯИС нь амжилтад хүрэх хичээл зүтгэлийг гаргах, хүний бүрэн чадавхаа ашиглах урам зоригоор дүүрэн орчинд эрчимтэй сургалтуудыг явуулдаг. БЯИС нь насан туршдаа тасралтгүй суралцах, бусдад үйлчлэх тэмүүлэл болон ур чадвартай оюутнуудад итгэл, оюун ухаан, зан төлөвийг төлөвшүүлэхийг эрмэлздэг.

- БЯИС нь оюутан бүрд сүнслэг үнэн, эрдэм шинжилгээний судалгаа, практикт суурилсан сургалтуудыг хослуулан; эрч хүч, тэмүүлэл дүүрэн суралцах орчин, нөхцөлийг бүрдүүлдэг.
- Мөн хоёр дахь шатны сургалтад хамрагдах, ажил мэргэжлээрээ ахиж дэвших боломжийн суурь болдог.
- Тус сургууль нь Үндэсний Коллежийн Атлетикийн Холбооны хөнгөн атлетикийн уралдаан тэмцээн, дэлхийн жишигт нийцсэн соёл урлаг, хөгжмийн тоглолтуудыг уламжлал болгон зохион байгуулдаг.

[cesinfo.byu.edu](http://cesinfo.byu.edu) хаягаас дэлгэрэнгүй мэдээлэл авна уу.

## АЙДАХО ДАХЬ БЯИС

Айдахо дахь БЯИС нь Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээний талаар гэрчлэлтэй болгож, түүний зарчмуудыг боловсролын түвшинд, соёлын хийгээд нийгмийн таатай орчинд хөгжүүлдэг. Хичээлээр янз бүрийн сонирхол, ур чадвартай оюутнуудад насан туршийн боловсрол, ажил хөдөлмөр эрхлэх чадвар олгоход чиглэсэн бодит туршлагаудыг санал болгодог. Айдахо дахь БЯИС нь чанартай боловсролыг бага зардлаар аль болох олон оюутанд олгохыг эрмэлздэг.

- 100 гаруй мэргэжлээр эрдмийн зэрэг олгодог.
- Багш нар тус тусын чиглэлээр мэргэшсэн бөгөөд оюутнуудад заан сургах, зөвлөн туслах ажлыг эн тэргүүнд тавьдаг.
- Анги дүүргэлтийн хувьд дунджаар 30 оюутантай.

[cesinfo.byu.edu](http://cesinfo.byu.edu) хаягаас дэлгэрэнгүй мэдээлэл авна уу.

## ХАВАЙ ДАХЬ БЯИС

Далайн болон Азийн бүс нутгийн оюутнуудад төвлөрдөг Хавай дахь БЯИС нь оюутнуудыг Есүс Христийн сургаалын дагуу амьдарч, соёл хоорондын эв нэгдэл, энх тайван байдлын үлгэр жишээ үзүүлэгчдийг бэлтгэдэг. Хавай дахь БЯИС-ийн төгсөгчид насан туршдаа үйлчлэхэд бэлтгэгдсэн байдаг. Тэд сэтгэн бодох оюуны чадвар, үйлчлэгч удирдагчийн зан чанар, төлөвийг нотлон харуулдаг.

- Оюутнууд өөр өөр чиглэлээр үндсэн нэг болон дагалдах хоёр мэргэжлийг сонгон суралцах эсвэл гэрчилгээ авахыг сонгож өөрсдийн эрдмийн зам мөрийг төлөвлөдөг.

[cesinfo.byu.edu](http://cesinfo.byu.edu) хаягаас дэлгэрэнгүй мэдээлэл авна уу.

## BYU-PATHWAY WORLDWIDE

BYU-Pathway Worldwide нь их сургуулийн боловсролын зэрэг авах боломжийг хүн бүрд олгодог.

Онлайнаар боловсрол эзэмшихийн уян хатан байдлыг хүсдэг болон боловсролдоо сэтгэл хангалуун байхыг хүсдэг эсвэл ахлах болон дунд сургуулиа төгсөөд юу хийхийг хүсэж байгаагаа олж мэдэхэд илүү их цаг зарцуулах хүсэлтэй суралцагчид BYU-Pathway Worldwide хөтөлбөрийн давуу талыг ашиглах боломжтой.

- BYU-Pathway Worldwide нь дэлхийн 180 гаруй орны суралцагчдад үйлчилдэг.
- Бүх хичээл онлайн бөгөөд бусад сургуультай харьцуулахад сургалтын төлбөр хямд төсөр байдаг.
- Суралцагчид хөдөлмөрийн зах зээлийн шаардлага хангасан гэрчилгээтэй төгсөх ба Айдахо дахь БЯИС болон Энзайн коллежоор дамжуулан онлайн сургалтаар боловсролын зэрэг авах боломжтой.
- Тус их сургуулийн санал болгодог гэрчилгээг авахад нэг жил болон түүнээс бага хугацаа шаардагдана.

[cesinfo.byu.edu](http://cesinfo.byu.edu) хаягаас дэлгэрэнгүй мэдээлэл авна уу.

## ЭНЗАЙН КОЛЛЕЖ

Энзайн коллеж нь Юта мужаас ирсэн оюутнуудад төвлөрч, Есүс Христийн чадварлаг, итгэлтэй шавь нарыг бэлтгэдэг. Ур чадварт суурилсан сургалтын хөтөлбөр нь нэгээс дөрвөн жилийн хугацаанд өрсөлдөхүйц цалинд хүрэхэд шаардлагатай туршлага хуримтлуулах боломжийг оюутнуудад олгодог. Сүнслэгээр тэжээгддэг оюун санааны орчин нь анги танхимд гүнзгий суралцах нөхцөлийг бүрдүүлдэг.

- Хүн бүр элсэх боломжтой.
- Тусгай дунд боловсрол, бакалаврын зэрэгтэй 25 гаруй гэрчилгээний сонголттой.
- BYU-Pathway Worldwide их сургуулиас онлайн гэрчилгээ, боловсролын зэрэг авах боломжтой.
- Оюутны холбоо нь олон талыг хамарсан оюутнуудаас бүрдсэн.

## CESINFO.BYU.EDU ХАЯГААС ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ АВНА УУ.ШАШНЫ ИНСТИТУТ

Институт бол сургуульд сурдаг эсэхээсээ үл хамааран өдөр тутмын амьдралын эгэл жирийн бодит үнэнтэй нүүр тулахын зэрэгцээ мөнхийн үнэнээр амьдрах хүсэлтэй найз нөхөдтэйгөө уулзахаар хуран цуглардаг газар билээ. Есүс Христтэй илүү адилхан болох бодит арга замуудыг залуучуудад нээж өгч, тэдгээрийг хэрэгжүүлэхэд туслах нь институтийн зорилго юм.

Институт бол итгэлийн аялалдаа яваа суралцагчдыг уулзуулдаг газар. Институт бол:

- Судар болон бошиглолын сургаалаас авсан Христэд төвлөрсөн сургалтын хөтөлбөр.
- Амьдралын сүнслэг болон бодит нөхцөл байдлыг хэрхэн удирдан чиглүүлэх талаар туршлага судлах газар.
- Хүндэтгэл, харилцан ойлголцол, аюулгүй байдал, асуултын хариулт, хэтийн төлөвийг олж авах газар.
- Онлайнаар болон биечлэн өгөх зааварчилгаа, семинар, харилцан ярилцах хэлэлцүүлэгт хамрагдах газар юм.

[institute.ChurchofJesusChrist.org](http://institute.ChurchofJesusChrist.org) хаягаас дэлгэрэнгүй мэдээлэл авна уу.